

БАТЛАВ

ХЭНТИЙ АЙМАГ/НИЙСЛЭЛ-ИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР /Ш.АРИУНБОЛОР/

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

Дугаар АТД-23-033/23

2023 оны 06 сарын 19-ны өдөр

Галшар

Үндэслэл	Аймгийн Засаг даргын 2021-2025 оны мөрийн хөтөлбөр,
1. Барилга байгууламжийн байршил тогтоосон газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрийн байршил, хэмжээ	Хэнтий аймгийн/нийслэл/ Галшар Сумын Засаг даргын захирамж -н 2018-09-25-нд, 02325-А/122/2018 тоот захирамжаар Галшар сумын/ дүүрэг/ 6-р баг, Буянтбулаг, Боловсролын байгууллага-ний эзэмших зориулалтаар 7234 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн.
2. Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал, хүчин чадлын нэгж	Галшар сумын 160 хүүхдийн Сургуулийн өргөтгөлийн барилга, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон Сургалт боловсролын байгууллагын барилга, Хүчин чадал: 160 хүүхэд,
3. Барилгажих талбай / төлөвлөлтийн талбайгаар/	5063
4. Барилгын төрөл, давхрын тоо	Цутгамал төмөрбетон каркасан бүтээцтэй, /зоорийн давхаргүй/ , 2 давхар
5. Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
6. Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл	Олон нийт
7. Эдэлбэр газар	7234 м2
Үүнээс:	<ul style="list-style-type: none">Барилгажих талбай: 5063- Барилгажих талбай 3880 м2-аас хэтрэхгүй, тухайн газрын 70 хувиас илүүгүй байна. /ХБТ Хууль 12.8/, Хот, тосгон төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/ дагууНогоон байгууламж, зам талбай: 2171- Эдэлбэр газрын 30 хүртлэх хувь /ХБТХууль 12.6.3/Авто зогсоол: Гадна талбайд авто зогсоол төлөвлөх /БНБД 21-05-10/ Авто зогсоолБусад:
8. Барилгажилтын улаан шугамын зай	Барилга байгууламж, зам талбайн улаан шугамыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн төлөвлөх.
9. Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага	Төлөвлөлтийн талбайд одоо байгаа ЕБСургуулийн барилга болон шинээр төлөвлөж буй өргөтгөлийн барилгын архитектур орон зайн төлөвлөлттэй уялдуулж ногоон байгууламж, явган хүний зам талбай, гэрэлтүүлэг төлөвлөх. Явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүйгээр онцгой нөхцөлд ашиглах авто машины орц гарц болон авто зогсоолыг "Олон нийт иргэний барилга" БНБД 31-03-03 норм бусад холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагыг үндэслэн төлөвлөх.

<p>10. Талбайн өндөржилтөд тавигдах шаардлага</p>	<p>Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгуудтай уялдуулж талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх.</p>
<p>11. Архитектур төлөвлөлтийн шаардлага</p>	<p>Төлөвлөж буй сургуулийн өргөтгөлийн барилга нь сумын төвийн өнгө үзэмжийг нэмэгдүүлсэн орчин үеийн шинэлэг хэв маяг өвөрмөц шийдлээр ашиглалтын зардал хэмнэсэн орон зайн төлөвлөлт гаргах, гадна фасад өнгө үзэмжтэй ашиглалтын шаардлага хангасан байх. Тухайн ЕБСургуулийн бүсийн барилгуудын өнгөний шийдэлтэй уялдуулж гадна фасаданд цагаан болон цэнхэр өнгийг зонхилох өнгө болгон сонгож ашиглалтын шаардлага хангасан шинэ технологи бүхий материал сонгон төлөвлөх. /БНБД 31-01-04/Иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байх./ БНБД 31-01-10/ - Галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулаас хамгаалах, нөхцөлийг төлөвлөлтөнд тусгах, /БНБД 21-01-02/, /БНБД 21-02-02/ - Цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байхаар төлөвлөгдсөн байх. - Олон нийт иргэний барилга /БНБД 31-03-03/ - Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/ - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдсөн байх./БД31-112-11, MNS6056:2009, MNS6055:2009/ - Ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, - Стандартын шаардлага хангасан камер, харуул хамгаалалтын алба, хяналтын цэгийн өрөө төлөвлөх. /MNS 6423:2013/ - Авто зам, явган хүний замыг орон нутгийн материал болох байгалийн чулуу, мод зэргийг ашиглан зохиомжилж төлөвлөх</p>
<p>12. Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага</p>	<p>Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг норм дүрэм стандартын дагуу төлөвлөх ба дулаан, цэвэр усан хангамж болон архиутгах татуургыг төвийн шугаманд холбох, дэд бүтцийн холболтын техникийн нөхцөлийг хангагч байгууллагаас авах, зөвшилцөх, техникийн нөхцөлийн дагуу зураглах.</p>
<p>13. Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, даган, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)</p>	<p>Инженерийн бэлтгэл арга хэмжээ орчны барилга байгууламжтай уялдуулж төлөвлөлтийн талбайн хэмжээнд иж бүрэн цогц байдлаар шийдэх Эдэлбэр газар зуралгалын тодруулалт хийлгэх, газар дээрхи болон дээрхи шугам сүлжээг тодруулсаны үндсэн дээр зураг төслийг боловсруулах.</p>
<p>14. Захиалагчийн нэр, хаяг, утас</p>	<ul style="list-style-type: none"> • Хуулийн этгээдийн оноосон нэр: Хэнтий аймгийн Галшар сумын ерөнхий боловсролын сургууль • Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9073469 • Холбоо барих утас: 99209993 • Цахим шуудан: munkhorgil.bymbajav@gmail.com • Хаяг: Галшар сум 6-р баг

<p>15. Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл</p>	<p>- Төлөвлөж буй барилгын гадна зам талбайг сумын төвийн одоо байгаа авто зам болон явган хүний зам талбайтай заавал холбож төлөвлөж хот байгуулалтын шаардлагыг хангах, төсөвт өртөгт тусгах, - Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм /БНБД 22-04-16/ болон MNS 6426:2013 стандартын холбогдох заалтуудын дагуу төлөвлөх, - Онцгой байдлын үед гал унтраах, аврах баг бүрэлдэхүүн саадгүй ажиллах боломжтой авто машин нэвтрэх боломжийг хангаж төлөвлөх, авто болон явган замын хөдөлгөөний урсгалын шийдлийг иж бүрэн гарган, зогсоол талбайг нэмэгдүүлэн төлөвлөх /ХБТХуулийн 12.6/, - "Барилгын дулаан хамгаалалтын норм"-ын шаардлагыг хангасан байхаар болон "ногоон" барилгын үзэл баримтлалыг тусган хэрэгжүүлэх,</p>
---	--

Онцгой нөхцөлд:


- Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
- Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.
- Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах, зөөх, засварлах, шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг архитектур төлөвлөлтийн даалгаварт хавсаргах.

Анхааруулга:

Барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа АТД-т заасан нэр, зориулалт, барилгын давхрын тоо, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд эскиз зураг батлагдахгүй болно.


Боловсруулсан:

Хэнтий аймгийн Ерөнхий архитектор бөгөөд ГХБХБГазрын Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн . . .  . . . /Ш.Ариунболор/



ХОТ БАЙГУУЛАЛТЫН
КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН
САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ

БАТЛАВ: “ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН” ХХК
ЗАХИРАЛ *Д.Баттүвшин* Д.БЯМБАДОРЖ



**ДУЛААН ХАНГАМЖИЙН ТӨВЛӨРСӨН СИСТЕМД ХЭРЭГЛЭГЧИЙГ
ХОЛБОХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №**

2023 оны 12-р сарын 25



1. **Барилга объектын нэр хаяг** : “160 хүүхдийн сургууль”-ийн барилга
2. **Барилга объектын байршил**: Хэнтий аймаг “Галшар сум”

А.Халаалт	0,094 Гкал/цаг
Б.Хэрэгцээний халуун ус	0.065 Гкал/цаг
В.Салхилуулга	0.00 Гкал/цаг
Нийт:	0,159 Гкал/цаг
3. **Дулааны холболтын цэг**:
“ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН” ХХКомпаний эзэмшил Дулааны худаг-5-аас 2Ф89 ган хоолойгоор огтолгоо авч Ф89 голчтой ган бөмбөлгөн хаалт 2 ширхэг байршуулан үл нэвтрэх төмөр бетон сувагт угсарна. Хоолойн гадуур пенополиуретан дулаалга хийж шилэн даавуугаар орооно. Тухайн барилгад тохирсон дулааны ачааллаар узельд холболт хийнэ. Холбогдох цэгийн өндөр хэсэгт хий авагч, нам цэгт ус буулгагч , таслах хаалт байршуулна.
4. **Зураг төсөл, төсөв боловсруулахад тавигдах шаардлага**:
 - 4.1 “Эрчим хүчний тухай хууль”-ийн 33 дугаар зүйл, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 1.3 дахь заалтыг мөрдөж дулааны төв шугам, салаа болон салбар шугамаас хамгаалалтын зурвасын зайг хангаж барилгыг төлөвлөх. Шугамын хамгаалалтын зурваст тохжилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.
 - 4.2 Архитектур төлөвлөтийн даалгавар, эскиз зургийг үндэслэн зураг төслийг хянана.
5. **Дор дурдсан техникийн даалгаврын дагуу зураг төслийг хийх**.
 - 5.1 Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаанд багтаан дулаан хангамжинд холбогдох.
 - 5.2 Гадна дулааны угсралтыг газарт сувагтай холбоно.
6. **Техникийн нөхцөлд тавигдах нэмэлт шаардлага**:
Төлөвлөж буй барилгын дулааны ачааллыг техникийн нөхцөлийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.
Холболтийг халаалт эхлэсний дараа буюу 10 дугаар сарын 01-ээс 05 дугаар сарын 01 ний хооронд хийхгүй болно.
Дулаанаар хангагч байгууллагад 2900 эрг/мин, 37 кВт, 120-140м түрэлттэй сүлжээний насос 2 ширхэг /CNP/ 45кВт-ийн давтамж хувьсгуур 1 ширхэг-ээр тус тус өргөтгөх
7. **Архивт бүрдүүлэх материал**:
Барилга хөгжлийн төвийн дүгнэлттэй гадна дулааны шугамын зурагийг автокад файлаар болон хэвлэмэлээр сумын архивт хадгалуулах.
8. **Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа**:
Энэхүү техникийн нөхцөл олгосоноос хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.
9. **Техникийн нөхцөлийг хүчингүй болгох**:
 - 9.1 Энэхүү техникийн нөхцөлийн заалтыг биелүүлээгүй.
 - 9.2 Техникийн нөхцлийн хугацаа дууссан.
 - 9.3 Техникийн нөхцлийн ачаалал 10 аас дээш хувиар өөрчлөгдсөн

Техникийн нөхцөл олгосон

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:


Д.Баттүвшин /Д.БАТТҮВШИН/

БАТЛАВ
СУМЫН ЗАСАГ ДАРГА  Д.НЯМБААТАР
ЗДТГазрын Техникийн нөхцөл гаргах комиссын
2024 оны 04-р сарын  ны шийдвэрийг үндэслэн зөвшөөрөв


ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №431/22

1	Барилга байгууламжийн нэр, зориулалт, байршил	Галшар сумын ЕБСургууль 2 давхар сургуулийн өргөтгөлийн барилга, Галшар сум 6-р баг, сургуулийн зүүн хойд талд
2	Нийт усны хэрэглээ	Цэвэр ус тооцоогоор: 3.6м ³ /хоног Галын ус тооцоогоор: 2.5м ³ /хоног Бохир ус тооцоогоор: 3.6м ³ /хоног
3	Цэвэр усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	Одоо байгаа сургуулиас зүүн хойно байрлах ДХ-5 худгаас 50мм-ийн диаметртэй шугамаар огтлогоо авна.
4	Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	Одоо байгаа сургуулийн зүүн хойно байрлах төвийн бохир усны шугамд холбогдно, Ажлын зүрийн түвшинд цэг тохиролцоно.
5	Нэмэлт нөхцөл	Бусад шаардлага: <ul style="list-style-type: none">• Төлөвлөж буй барилга доорх одоо байгаа бохир усы шугамыг буулгаж, шинээр шилжүүлэн угсрахаар ажлын зургийг хийж гүйцэтгэнэ.
6	Тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none">• Стандарт шаарлага хангасан гарал үүсэл тодорхой материал ашиглах
7	Объект барих дээд газрын шийдвэр	<ul style="list-style-type: none">• Төрийн байгууллагын газар эзэмших Дугаар 000002285 гэрчилгээ• 2023 оны 06 сарын 19-ны АТД 23-033/23 дугаартай архитектур төлөвлөгөөний даалгавар
8	Хэрэглэгчийн нэр, утас	С.Тогоохүү 99568331

БАЙРШЛЫН СХЕМ



Д/Д	ТОДОРХОЙЛОЛТ	ТАЙЛБАР
1	Сургуулийн өргөтгөл	Төлөвлөж дүй
2	Сургууль	Одоо байгаа
3	Спорт заал	Одоо байгаа



БАТЛАВ
БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ СҮЛЖЭЭ Н.МӨНГӨНХӨЛӨГТ



2024 оны 02 дугаар сарын 05

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2024 оны 02 дугаар сарын 29

№ ХЭ 24/01-2

Багануур дүүрэг

1. Техникийн нөхцөл
хүссэн хуулийн этгээд:

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий
боловсролын сургууль

2. Хэрэглэгчийн хаяг:

Хэнтий аймаг, Галшар сум
Утас: 70566510

3. Хэрэглэгчийн байршил,
зэрэглэл:

Хэнтий аймаг, Галшар сум
3-р зэрэглэл

4. Ажил үйлчилгээний
зориулалт:

160 хүүхдийн сургуулийн гадна цахилгаан
хангамж (өөрчлөлт)

5. Техникийн нөхцөл
олгох үндэслэл:

5.1 Хэнтий ЦТСС-ын 2023 оны 12 дугаар
сарын 20-ны өдрийн №01/556 дугаартай
албан бичиг.

5.2 Хэнтий аймгийн Галшар сумын ерөнхий
боловсролын сургуулийн 2024 оны 02 дугаар
сарын 27-ны өдрийн №06 дугаартай албан
бичиг.

6. Хүчин чадал:

250 кВА

7. Холбогдох цэг:

7.1 35/10 кВ-ын Галшар дэд станц 10 кВ-ын
Гэр байр гаргалгааны реле хамгаалалтыг
микропроцессорын реле хамгаалалтаар
шинэчилнэ.

7.2 35/10 кВ-ын Галшар дэд станцын 10 кВ-
ын Гэр байр ЦДАШ-ын тулгуур №2-с
салбарлана.

7.3 Тулгуур №2 дээр 10 кВ-ын цэнэг
шавхагч, хуурай салгуур, гэмтэл заагч
суурилуулна.

7.4 Шинээр угсарсан хуурай салгуураар
дамжуулан 3*70 мм²-с багагүй хөндлөн
огтлолын талбайтай, газарт булах
зориулалттай 10 кВ-ын цахилгаан

дамжуулах кабель шугам татна.

7.5 Шинээр угсарсан кабель шугамын төгсгөлд нь **250 кВА** чадалтай 10/0.4 кВ-ын хүчний трансформатор бүхий КТПН маягийн иж бүрэн дэд өртөөг угсарна.

7.6 10/0.4 кВ-ын дэд өртөөний 10 кВ талд ачаалал таслагч, гал хамгаалагч, цэнэг шавхагч, 0.4 кВ талд нь ачаалалдаа тохирсон ерөнхий рубильник, гал хамгаалагч, гаргалгааны автомат бүхий 0.4 кВ-ын иж бүрэн тоноглол суурилуулна.

8. Тоолуур хэмжих хэрэгсэл:

8.1 Шинээр угсрах 10/0.4 кВ-ын дэд өртөөний 0.4 кВ талд Монгол улсын Стандарт, хэмжил зүйн газрын загварын туршилтад орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан, гэрчилгээтэй, IEC 61861-1 стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, IEC 62052-11, IEC 62053-22, IEC 62053-24 стандартын шаардлага хангасан "БЗӨБЦТС" ТӨХК-д ашиглагдаж буй "Ухаалаг тоолуурын систем"-д ВРLС модуль бүхий дата концентраторын тусламжтайгаар мэдээллийг бүрэн дамжуулж интеграци хийх боломжтойгоор программчлагдсан 0.5S нарийвчлалтай, олон үйлдэлт 5 А-ын ухаалаг тоолуур, дата концентраторын (өгөгдөл дамжуулагчийн) хамт суурилуулна.

9. Тусгай заалтууд:

9.1 Шинээр угсрах цахилгаан дамжуулах кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөөний ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн, техникийн нөхцөл олгогчоор хянуулж магадлан хяналтаар баталгаажуулна.

9.2 Шинээр угсрах 10/0.4 кВ-ын дэд өртөө, цахилгаан дамжуулах кабель шугамын трассын зураг, схемийг Хэнтий ЦТСС-ын инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.

9.3 Шинээр угсрах ЦДАШ, 10/0.4 кВ-ын дэд өртөөний газардуулгын байгууламжийн тооцоог хийж, тогтоосон дүрэм журмын шаардлагад хүргэж, "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн дагуу газардуулга хийнэ.

9.4 Шинээр угсрах цахилгаан дамжуулах кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөө нь

бусдын эзэмшлийн газар, инженерийн байгууламжийг огтлолцож байгаа цэгүүдэд холбогдох эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл авна.

9.5 Хэнтий аймгийн газрын албанаас шинээр баригдах 10 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын трассын дагуу газрын зөвшөөрөл авч баталгаажуулан мэдээллийн нэгдсэн санд оруулна.

9.6 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдэлийн түвшингийн $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй, орчин үеийн шинэ тоног төхөөрөмж суурилуулна.

9.7 Шинээр угсрах цахилгаан дамжуулах кабель шугам, 10/0.4 кВ-ын дэд өртөөний барилга угсралтын ажлыг “Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл”-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.8 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай хэмжилт туршилтыг БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий ЦТСС-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

9.9 Хэрэглэгч нь 35/10 кВ-ын Галшар дэд станцын 10 кВ-ын Гэр байр гаргалгааны реле хамгаалалтын тавилын тооцоо, зохицуулалтыг БЗӨБЦТС ТӨХК-иар хийлгэнэ.

9.10 Хэрэглэгч нь 35/10 кВ-ын Галшар дэд станцын 10 кВ-ын Гэр байр гаргалгааны гүйдлийн трансформаторын ачааллыг тооцож, шаардлагатай тохиолдолд гүйдлийн трансформаторыг солино.

9.11 Шинээр суурилуулах 10/0.4 кВ-ын КТПН маягийн дэд өртөөнд “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн дагуу хашаа хийнэ.

9.12 Тухайн хэрэглэгч нь түгээх сүлжээнд холбогдсон нөхцөлд цахилгааны хэрэглээ, цахилгаан тоног төхөөрөмжийн ажиллагаа нь түгээх сүлжээний үндсэн параметр болох

хүчдэл, давтамжийн утгад нөлөөлж нэгдсэн сүлжээний дүрэмд заасан зөвшөөрөгдөх утгаас хэлбэлзэх, огцом буурах, өсөх, тоноглолын ачаалагдах хэмжээ зөвшөөрөгдөх хязгаараас давах мөн байгалийн онц ноцтой хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн түгээх сүлжээний үйл ажиллагаа доголдох, саатах нөхцөл байдал үүссэн тохиолдолд түгээх сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангахын тулд хугацаа харгалзахгүй цахилгаан эрчим хүчээр хязгаарлах, түдгэлзүүлэх нөхцөлөөр холбогдоно.

9.13 35/10 кВ-ын Галшар дэд станц 10 кВ-ын Гэр байр гаргалгаанд 3×95 мм²-аас багагүй хөндлөн огтлолтой газарт булах зориулалт бүхий цахилгаан дамжуулах кабель шугам татна. 10 кВ-ын шинэ ХХБ-ийн 10 кВ-ын Сумын төв гаргалгаанаас тэжээх боломжтой урттай байна.

10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 3.1-3.5 дугаар заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтад хүлээн авах журам"-ын дагуу холбогдоно.

10.2 Цахилгаан тоноглол болон агаарын шугам, кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий ЦТССалбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

10.3 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.4, 30.1.7, 30.1.8 дугаар заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

10.4 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.5 Хэрэглэгч нь “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.6 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.7 Хэрэглэгч нь “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн заалтуудыг баримталж угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

10.8 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2 дахь хэсэгт заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

2.16 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана.

2.17 Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

2.17.1 Хүчинтэй хугацаа дууссан;

2.17.2 Техникийн нөхцөл авахдаа Ошаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

2.17.3 Холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн.

10.9 Техникийн нөхцөлд тусгагдсан заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.

10.10 Техникийн нөхцөлийн дагуу барилга угсралтын ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн түгээх сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

10.11 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13-д заасны дагуу техникийн нөхцөлийн дагуу зураг төслийн байгууллагаар хийлгэж, холбогдох байгууллагаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

10.12 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгуулахдаа хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.16-д заасны дагуу баталгаажуулсан зураг төслийг ирүүлнэ. Хэрэв баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгахгүй.

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ТҮАХБ ХЭЛТСИЙН ДАРГА

ШҮГ ХЭЛТСИЙН ДАРГА

ЗУРХА АЛБАНЫ ДАРГА

ТХ АЛБАНЫ ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ТҮАХБ ХЭЛТСИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ
ХАРИУЦСАН ИНЖЕНЕР

А.АЗБАЯР

051111246

Б.ТӨМӨРХУЯГ

Н.АМАРСАЙХАН


Д.МЯГМАРСҮРЭН

Д.НЯМДОРЖ

Л.МӨНХ-ЭРДЭНЭ



ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар А-42

/Хэнтий аймаг/

2023 оны 12 сарын 21 өдөр

Захиалагч байгууллага: Төгс Гранд ХХК

Хэрэглэгчийн нэр: захирал П.Ундармаа

Харилцах утас: 80055733

Байршил: Хэнтий аймаг Галшар сум

Зориулалт: шинэ ЕБС-ийн гадна холбоожилт


Сувагчлалаар татах шилэн кабелийн хэрэгцээ:					
д/д	Чиглэлийн нэр:	Кабелийн марк , багтаамж, урт	Агаарын багана /ш/	Сувагчлал /м/	Худаг
1	МХС байнаас шинэ барилга хүртэл агаараар	SM/ 4с/ А/ 380		-	-
2	Бусад тоноглол /төгсгөлийн төхөөрөмж /		бетонон багана 7ш, холбоо талд 12с FDF 1ш, сургууль талд 4с FDF 1ш	-	-
3	Нийт	380	7/1/1	-	-

1. Техникийн онцгой нөхцөл: Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга объектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

2. Техникийн үндсэн нөхцөл:

- 2.1 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэнэ.
- 2.2 Худаг сувагчлалаар шинээр шилэн кабель суурилуулахдаа Монгол Улсын MNS 5207:2011, MNS 5278:2012, MNS 5317:2011 стандартуудыг мөрдөнө.
- 2.3 Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах нэгжид мэдэгдэн ажил эхлэх зөвшөөрөл авна.

- 2.4 Техникийн нөхцлийн дагуу гүйцэтгэсэн ажлыг техникийн актаар хүлээлгэн өгөөгүй тохиолдолд түүнд гарах аливаа эрсдэл, гэмтэл саатлын хариуцлагыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.
- 2.5 Техникийн нөхцлийн дагуу худаг сувагчлалын түрээсийн гэрээ байгуулна.
- 3. Угсралтын ажлын үед тавигдах шаардлага:**
- 3.1 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтран хяналт тавьж, угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.
- 3.2 Шилэн кабелийг худагт нөөц үлдээхгүй татах бөгөөд зөвхөн төгсгөлийн төхөөрөмж байрлуулах хэсэгт нөөц авахыг зөвшөөрнө.
- 3.3 Шинээр татсан кабельд биркийг /хаягжилт/ худаг бүрт болон төгсгөлийн төхөөрөмжид бүрэн хийсэн байх ба худагт кабелийн залгаа хийх тохиолдолд муфтыг худгийн хананд тусгай тавиур хийж байрлуулсан байх.
- 3.4 Кабелийг техникийн нөхцөлд заасан трассын дагуу татаагүй тохиолдолд ашиглалтын явцад гарах эрсдэлийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.
4. Угсралтын ажил дууссаны дараа тухайн ажлыг AutoCAD-ын гүйцэтгэлийн зураг хийлгэж, тухайн ашиглалт хариуцсан газарт техникийн актаар хүлээлгэн өгнө.
5. Техникийн нөхцлийг Төгс гранд ХХК-ны захирал П.Ундармаагийн 2023 оны 12 сарын .19....-ний өдрийн албан бичиг, хүсэлтийг үндэслэв.
6. Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалт хийлгэх хүсэлт хүлээн авч, сунгах боломжтой.

Хянасан:  Ерөнхий инженер Т.Баярмаа

Боловсруулсан:  ДБИнженер Н. Оюун-Эрдэнэ